



# СЭЛЭНГЭ АЙМГИЙН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ 2018- VI





## ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ - Эрүүл мэнд



2018 оны эхний 6 сарын байдлаар манай аймагт бусад аймаг хотоос бүгд 1456 хүн шилжин ирж, 1361 хүн шилжин явсан байна. Нийт шилжин ирэгсдийн 48.0 хувь нь эрэгтэйчүүд, 52.0 хувь эмэгтэйчүүд байгаа бол нийт шилжин явагсдын 48.2 хувь нь эрэгтэйчүүд, 51.8 хувь нь эмэгтэйчүүд байна.



2018 оны эхний 6 сарын байдлаар аймгийн хэмжээгээр нийт 861 эх төрж, 861 хүүхэд мэндэлсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс төрөлт 7.4 хувиар өссөн байна.



Нас барсан хүний тоо 150 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 5.9 хувиар өссөн байна. 0-1 хүртлэх хүүхдийн эндэгдэл 11, 1-5 хүртлэх насны хүүхдийн эндэгдэл 3 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна. Нийт нас баралтын шалтгааны 13.2 хувь нь осол гэмтлийн, 27.2 хувь нь хорт хавдрын өвчний шалтгаантай байна.



Халдварт өвчнөөр 495 хүн өвчилж бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 39.4 хувиар өссөн байна. Нийт халдварт өвчний 71.1 хувийг бэлгийн замын халдварт өвчин, 20.4 хувийг сүрьеэ, 8.5 хувийг бусад халдварт өвчин эзэлж байна.




2018 оны эхний 6 сард нийт 199443 үзлэг хийсний 29.9 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 7.2 хувь нь гэрийн идэвхитэй үзлэг, 14.4 хувь нь диспансерийн хяналтын үзлэг эзэлж, нийт 17202 дуудлаганд үйлчилсний 12.8 хувийг алсын дуудлагаар үйлчилж яаралтай тусламж үзүүлжээ.



## ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ - Эрүүл мэнд

Төрсөн эх, амьд төрсөн хүүхэд






## ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ- Хөдөлмөр



377



455

### Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд



Өмнөх оны  
мөн үе  
26.9%




Өмнөх  
сарын  
Мөн үе  
3.5%



Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн иргэд 2018 оны 6 дугаар сарын эхэнд 862 байсан бөгөөд ажилд зуучлагдаг орсон 402, идэвхгүйн улмаас хасагдсан 85, шинээр нэмэгдсэн 457, сарын сүүлд бүртгэлтэй ажилгүй 832 иргэд байна.

### БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮД БОЛОВСРОЛЫН ТҮВШИНГЭЭР



Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 307 (26.9%) хүнээр, харин өмнөх сараас 30 (3.5%) хүнээр тус тус буурчээ, 832 болсны 455 (54.7%) нь эмэгтэйчүүд байна.





## ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ- Нийгмийн даатгал, халамж

01

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын газрын мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2018 оны эхний 6 сард 16756.3 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2485.8 (17.4%) сая төгрөгөөр өссөн байна.

Харин нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 8569.4 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 902.7 (11.8%) сая төгрөгөөр өссөн байна.

02

2018 оны 6 сарын байдлаар тэтгэврийн даатгалын сангаас 16221 тэтгэвэр авагчдад 30769.8 сая төгрөгийг тэтгэвэрт, тэтгэмжийн даатгалын сангаас 3643 даатгуулагчдад 1388.4 сая төгрөгийг ХЧТА, ЖА, оршуулгын тэтгэмжид, ҮОМШӨ-ний даатгалын сангаас ҮО-ийн тэтгэвэр, ХЧТА-ны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 251 хүнд 589.9 сая төгрөг, Ажилгүйдлийн даатгалын сангаас 257 даатгуулагчдад 341.3 сая төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид тус тус олгожээ.

03

Нийгмийн халамжийн сангаас 36415 хүнд 7254.9 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг олгожээ.



## ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ- Гэмт хэрэг




2018 оны эхний 6 сарын байдлаар нийт 368 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 4.5 хувиар өссөн байна. Нийт гэмт хэргийн 26.9 хувь нь согтуугаар үйлдэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 20.8 хувиар буурсан байна.

Иргэн болон байгууллагад нийт 579.3 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үеэс 262.7 сая төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирлоос 274.5 сая төгрөгийг нөхөн төлүүлж, нөхөн төлөлт 33.9 хувьтай байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 21.4 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 42.7 хувийг хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 10.9 хувийг нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 8.2 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 16.8 хувийг бусад төрлийн гэмт хэрэг эзэлж байна. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 16.4 хувийг малын хулгай эзэлж байна.


Бүртгэгдсэн гэмт хэрэг, төрлөөр, хувиар





Сэлэнгэ аймгийн Алтанбулаг болон Сүхбаатар боомтоор давхардсан тоогоор 329317 зорчигч нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеээс 50.5 хувиар өссөн байна. Нийт зорчигчдын 80.9 хувь нь Монгол иргэд, 19.1 хувь нь гадаад иргэд байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хилээр нэвтэрсэн Монгол иргэдийн тоо 39.1 хувиар өсч, гадаад иргэдийн тоо 30.9 хувиар өссөн үзүүлэлтэй байна. Монгол-Оросын хилийг хялбарчилсан журмаар хил нэвтрэх эрхийн үнэмлэхээр 21598 хүн зорчсон байна.

Хилээр орсон гарсан иргэд





## МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ–Банкны мэдээ

01

Монгол банкны мэдээгээр энэ сард кассын цэвэр орлого 59405.2 сая төгрөг, цэвэр зарлага 58548.5 сая төгрөгт хүрчээ.Зээлийн өрийн үлдэгдэл 268004.6 сая төгрөг байгаа ба үүний 2.3 хувийг чанаргүй зээл эзэлж байна. Иргэдийн мөнгөн хадгаламж 82722.8 сая төгрөг байна.

02

2018 оны эхний 6 сарын байдлаар иргэдийн мөнгөн хадгаламж 82722.8 сая.төг төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 15067.0 (22.3%) сая.төгрөгөөр өссөн байна.

03

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2018 оны 6 дугаар сарын эцэст 6190.0 сая төгрөг болж, өмнөх сараас 518.0 (1.5 %) сая төгрөг буурсан бол өмнөх оны мөн үеэс 723.5 (13.2 %) сая төгрөгөөр өссөн байна.



## МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ–Банкны мэдээ

Банкууд	Цэвэр		Зээлийн өрийн үлдэгдэл	Чанаргүй зээл	Иргэдийн мөнгөн хадгаламж	Харилцахын үлдэгдэл
	Орлого	Зарлага				
ДҮН	59,405.2	58,548.5	268,004.6	6,190.0	82,722.8	39,346.7
1.Хаан банк СБ	16411.0	14502.9	97244.9	1684.7	24545.5	11276.8
2.Хаан банк ЗХ	7932.6	8086.6	45984.9	562.9	11147.9	15751.5
3.ХХБанк ЗХ	2674.2	2526.4	8651.2	12.6	3315.3	3147.1
4.ХХБанк Хөтөл	3407.9	4086.7	8009.7	290.0	1955.8	1061.0
5.Төрийн банк СБ	17496.6	17439.6	46772.2	726.0	16517.1	4587.5
6.Төрийн банк ЗХ	5692.3	5978.6	12008.2	25.5	4646.4	771.6
7.Хас банк СБ	1422.7	1415.2	15688.8	480.1	6466.0	1034.6
8.Хас банк ЗХ	1233.3	1179.4	13048.7	273.8	5178.4	405.1
9.Хас банк Хөтөл	792.8	775.0	5172.2	328.7	2077.7	148.0
10.Голомт банк	2298.4	2392.9	15020.2	1669.6	5876.1	1042.9
11.Капитал банк	43.4	165.4	403.6	136.1	996.6	120.6





## МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ–Банкны мэдээ



40.3 төгрөг  
өмнөх оны  
мөн үеэс  
0.3 төгрөг буюу  
0.7% суларчээ



2474 төгрөг  
өмнөх оны  
мөн үеэс  
84.0 төгрөг  
буюу  
3.5% өсчээ




372.0 төгрөг  
өмнөх оны  
мөн үеэс  
19.0 төгрөг  
буюу  
5.4% өсчээ



## МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ–Төсөв

2018 оны 06 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр орон нутгийн төсвийн орлого 8'392.8 сая төгрөг буюу 96.2 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Үүнээс аймгийн төсвийн орлого 5'922.9 сая төгрөг буюу 92.1 хувийн гүйцэтгэлтэй, сумдын төсвийн орлого 2'469.8 сая төгрөг буюу 107.8 хувийн гүйцэтгэлтэй байна. 2018 оны 06 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр орон нутгийн төсвийн зарлага 38'315.5 сая төгрөг буюу 83.5 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Үүнээс орон нутгийн төсвийн байгууллагуудын зарлага 12'607.7 сая төгрөг буюу 67.7 хувь, Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зарлага 25'707.7 сая төгрөг буюу 94.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл /сая.төг/






## ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хөдөө аж ахуй

2018 оны эхний 6 сарын байдлаар 585.4 мянган эх мал төллөсөн нь урьд оны мөн үеэс 53.6 мянган толгой буюу 10.1 хувиар нэмэгдсэн байна. Мал төллөлтийн хувь Ерөө, Сүхбаатар, Жавхлант сумдад өндөр буюу 90.4-98.7 хувьтай байна.

Аймгийн хэмжээнд 579.4 мянган толгой төл бойжиж байгаа нь урьд оны мөн үетэй харьцуулахад 67.7 мянган толгой буюу 13.2 хувиар их байна.

2018 оны эхний 5 сарын байдлаар оны эхний нийт малын 0.6 хувьтай тэнцэх 10090 толгой мал хорогдсон нь урьд онтой харьцуулахад 4.8 дахин бага байна. Хорогдсон нийт малын 4.3 хувь нь өвчнөөр хорогдсон, 27.3 хувь нь хээлтэгч малын хорогдол байна. Хорогдсон нийт малын 6388 толгой буюу 63.3 хувь нь Мандал, Орхонтуул, Баруунбүрэн сумдад ногдож байна.

Төмс, хүнсний ногоо тариалсан талбай /мян.га/






## ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Аж үйлдвэр

2018 оны 2-р улирлын байдлаар аж үйлдвэрийн салбарт 163247.6 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 165580.4 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн нь урьд оны мөн үеийнхээс борлуулалт 3.5 тэр бумаар буюу 2.1 хувиар буурсан бол үйлдвэрлэлт 23.4 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан байна. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 27.5 хувь нь хүнсний салбарт, 56.5 хувь нь уул уурхайн салбарт, 3.5 хувь нь бусад салбарт, 12.5 хувь нь барилгын материалын салбар бүтээгджээ.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт (тэр.бум.төг)





# СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?

Статистик мэдээллийн лавлах утас 1900-1212

Статистик мэдээллийн нэгдсэн сан WWW.1212.mn

## Статистик мэдээллийн аппликейшн



Сэлэнгэ Статистик

Selenge.nso.mn

www.nso.mn сайтын Хэрэглэгчийн бүртгэл мэдээлэл авах



@statistic\_mn

Олон улсын худалдааны төв, төрийн үйлчилгээний танхим



Утас: 70362449  
70362047